

**“ХӨХ ХОТ” ҮНДЭСТНИЙ ДЭЭД СУРГУУЛЬ БОЛОН СОЁЛ
УРЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН МЭРГЭЖЛИЙН УРТЫН ДУУЧИН
БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХАРЬЦУУЛАН
СУДАЛСАН УРЬДЧИЛСАН ДҮНГЭЭС**

**Сайнбаярын Уянга /WUYUNGA/^{1,*}
Цэрэнгийн Чулуунцэцэг²**

¹ Монгол улсын боловсролын их сургуулийн докторант, Улаанбаатар, Монгол улс

² Доктор (Ph.D), дэд профессор, Соёл урлагийн их сургууль, Улаанбаатар, Монгол улс

* Холбоо барих зохиогч: 385333953@qq.com

**A PRELIMINARY RESULT OF THE COMPARATIVE RESEARCH OF
THE CURRICULA FOR THE PREPARATION OF LONG-SONG
SINGERS OF THE NATIONAL INSTITUTE OF KHUKH KHOT CITY
AND THE UNIVERSITY OF ARTS AND CULTURE**


**Uyanga Sainbayar^{1,*}
Chuluuntsetseg Tseren²**

¹ Doctoral student of Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

² Doctor (Ph.D), Associate Professor, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

* Corresponding author: 385333953@qq.com

Хураангуй: Судлаачид их сургуулийн боловсрол болох мэргэжлийн уртын дуучдын сургалтын хөтөлбөрийг гүнзгийрүүлэн судалж, хөтөлбөрийг уламжлалт байдлаар хэрэгжүүлэх, мөн мэргэжлийн багш нарыг сургахад чиглүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэсээр байна. Судалгааны зорилго нь мэргэжлийн дуучдыг сургах онол, арга зүйн судалгааг үндэслэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үндэслэлийг тодорхойлоход оршино. Судалгаанд Монгол улсын Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургуулийн уртын дуучин бэлтгэхэд зориулсан хөтөлбөр болон Өвөр Монголын Хөх хотын үндэстний дээд сургуулийн дуу урлагийн салбар сургуулийн хөтөлбөр, сургалтын программ, онолын ном, судалгааны материалыг ашигласан. Бид мэргэжлийн уртын дуу дуулаачдыг бэлтгэх сургалтын онол, арга зүйг судалж, Өвөр Монголын Хөх хотын үндэстний дээд сургуулийн уртын дуунд суралцаж байгаа оюутнуудын дуулах ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчилж, түүний үр дүнг судлах нь чухал хэмээн үзлээ.



Түлхүүр үг: сургалтын хөтөлбөр, урын сан, арга зүй, угсаатан, үнэт зүйл, суралцагч, уртын дуу, дуучин

Abstract: Researchers have emphasized that it is necessary to profound the study of the program for training professional singers, as a university education and to carry out the program in a traditional way as well as to direct towards training professional teachers. The purpose of the research is to determine the evidence for reforming the curriculum on the basis of the study of the theory and methodology of training professional singers.

The theory books, research materials and curriculum for the preparation of long-song singers of the school of the music art of the MSUAC and the professional organizations which work out the curriculum and training programs of the branch school of the song art of the National Institute of Khukh Khot city of the Inner Mongolia were used.

We concluded that it is necessary to update the training program for the development of the singing skills of the students who study in the field of long-song singing at the National Institute of Khukh Khot city of the IMAR through the study of the training theory and methodology of the preparation of the professional long-song singers and it is also significant to test and study its result.

Keywords: *result of learning, repertoire, methodology, ethnic group, value, student, long song, singers*

Үндэслэл: Дуулаачийн мэргэжлийн боловсролын салбарт угсаатны хөгжмийн үнэт зүйлс, уламжлалт онцлогийг шингээсэн хөтөлбөрийн шинэчлэлт хийх хандлага дэлхийн олон улс орнуудад амжилттай хэрэгжиж байна. Дэлхийн улс орнууд боловсролын бодлогын зорилгоо хүн төрөлхтний нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд оролцох мэдлэг, чадвартай, зөв хандлагатай, бүтээлч, насан туршдаа суралцах чадвартай иргэн төлөвшүүлнэ хэмээн тодорхойлж байна.

Сүүлийн жилүүдэд сургалтын хөтөлбөр боловсруулах үзэл баримтлал тусгайлан боловсруулж, түүнийг хөтөч үзэл болгон, хөтөлбөр боловсруулдаг болсон билээ (Жилээ, Тамир, Дэлгэржаргал, 2020, 73). Боловсролын үндэсний хөтөлбөрт (2010-2021) “Бүх шатны хөтөлбөрийг олон улсын боловсролын нийтлэг жишигт нийцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр хичээллэх боломжоор хангах” хэмээн заасан нь бодлогоор хөтөлбөрийн шинэчлэл хийж, дэлхийн жишигт хүргэх зорилго тавьсныг харуулж байна (Жилээ, Тамир, Дэлгэржаргал, 2020, 74). Тиймээс хөтөлбөрийн харьцуулсан судалгаа хийх нь хөтөлбөрийн шинэчлэлд чухалд тооцогдоно.

БНХАУ-ын Өвөр Монголын багш, судлаачдын хуримтлуулсан сургалтын үзэл, боловсруулсан дэг, түүнийг хэрэгжүүлж ирсэн арга туршлагыг нэгтгэсэн, дүн шинжилгээ хийсэн судалгааны ажил цөөн байна (Боловсролын хэрэг эрхлэх яам, 2012, 16).

Мэргэжлийн уртын дуу дуулаач нь уртын дууг амьдруулах ухаан, урын сангийн утга агуулга, дуулалтын донж, хэв маяг зэргийг мэдэрч дадуулах хэрэгтэй. Иймээс уртын дуучин бэлтгэх мэргэжлийн сургалтын арга зүй, хөтөлбөр, ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн цогц сургалтын боломжийг суралцагч болон багш нар эрэлхийлэх шаардлагатай хэмээн дүгнэжээ (Мандалт, 2018, 46).

“Хөх хот” үндэстний дээд сургуулийн сургалт нь уламжлалт арга барилаар явагддаг, мэргэжлийн багш бэлтгэхэд чиглэсэн байдаг тул багш, судлаачид сургалтын онол, арга зүйн түвшин, түүнийг судлан тодруулах, мэргэжлийн дуучин бэлтгэх сургалтын хөтөлбөрийн судалгааг нарийсгах шаардлагатайг онцолсоор байна.


Зорилго: ӨМ-ын “Хөх хот” үндэстний дээд сургууль нь мэргэжлийн уртын дуу дуулаачдыг бэлтгэх тусгайлсан хөтөлбөргүй, “Дуулах урлаг” гэсэн нэгдсэн хөтөлбөртэй байгаа нь энэхүү харьцуулсан судалгааг хийх үндэслэл болсон. Ийм учраас сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийх, суралцагчдын дуулах ур чадварыг хөгжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах шаардлага урган гарч байна. СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн мэргэжлийн уртын дуу дуулаач бэлтгэх сургалтын хөтөлбөрийн агуулга, боловсруулсан арга, аргачлал, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын цаг, сургалтад заагддаг дуу зэргийг судалж ӨМӨЗО-ны “Хөх хот” үндэстний дээд сургуулийн хөтөлбөрийн ялгаатай болон ижил төстэй талуудыг харьцуулан судлах зорилготой.

Судалгааны зорилт

1. СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн “Дуулах урлаг” уртын дууны сургалтын хөтөлбөрийг судлах
2. “Хөх хот” үндэстний дээд сургуулийн дуу урлагийн салбарын мэргэжлийн дуулаач бэлтгэдэг хичээлийн хөтөлбөрийг судлах
3. Мэргэжлийн уртын дуу дуулаач бэлтгэх сургалтын онол арга зүйг судлах замаар СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн “Дуулах урлаг” уртын дууны хичээлийн хөтөлбөр, ӨМ-ын “Хөх хот” үндэстний дээд сургуулийн “Дуулах урлаг” хичээлийн хөтөлбөрийг харьцуулан судалж, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг болно.

Хэрэглэгдэхүүн: Судалгаанд дараах бичиг баримтыг судалгааны хэрэглэгдэхүүн эх материалаар ашиглана. Үүнд:

1. Тус сургуулиудын мэргэжлийн дуулаач бэлтгэх сургалт явуулсан сүүлийн 5 жилийн хөтөлбөр
2. Мөн сургуулиудын мэргэжлийн дуулаач бэлтгэх сургалтын төлөвлөгөө
3. Сургалт явуулсан багшийн журнал (ямар дууг, аль ангийн элсэгчдэд заасан, хэдэн дуу заасан гэх мэтийг үнэлэх)
4. Суралцагчдын хичээлийн явцын үнэлгээ зэрэг бичиг баримтуудыг ашиглана.



Зураг 1. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний арга зүйн загвар

Үр дүн: Өвөр Монголын “Хөх хот” үндэстний дээд сургуулийн урлагийн салбарын “Дуу хөгжим сургалтын хөтөлбөр” нэртэйгээр 0701115 хичээлийн дугаартайгаар нийт 136 кредит цагийг дөрвөн жилд үздэг хөтөлбөр байна. Энэхүү хөтөлбөрийг 2015 онд баталсан бөгөөд одоог хүртэл шинэчлээгүй байна. Уртын дууны сургалтын үндсэн хөтөлбөрийг боловсруулах зарчим нь сургалтын цагийн төлөвлөлт, сургалтын дүрэм журмын зохицуулалт ба кредит цагийн хэмжээ, кредитийн хуваарилалт, сургалтын тогтолцоо, боловсролын бакалаврын зэргийг хамгаалах мэргэжилтнийг бэлтгэх хөтөлбөрийн нөхцөл гэсэн үндсэн 5 хэсэгтэй. Энэ нь нийтлэг нэг хөтөлбөр болгон мөрдөх онцлогтой. Уртын дуучин бэлтгэх ур чадварыг хөгжүүлэх зорилго, суралцагчийг хүмүүжүүлэх, сургалтын тодорхойлолт, сургалтын төлөвлөгөө гэсэн тухайн мэргэжилд хамаарах дагалдах 4 хэсэгтэй байдаг байна. Дуулах ур чадвар хөтөлбөрийг тусгайлан баталж чиглүүлээгүй байна.

Уртын дууны мэргэжлээр суралцагч оюутан нь ямар сурах бичиг, CD, DVD, цахим эх сурвалж ашиглах, суралцахуйн үр дүнд хэрхэн хүрэх, суралцахуйн үр дүнд хүрсэн эсэхийг хэрхэн үнэлэх хичээлийн зорилгын хамаарал зэргийн тухай тодорхой зааж өгсөн зүйл байхгүй. Хөтөлбөрт багш нарын бүрэлдэхүүн, мэдээлэл, сургалтын арга зүй зэрэг нь тусгагдаагүй байгаа нь харьцуулж буй хөтөлбөрийн бичиг баримтаас харагдаж байна.

СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль нь мэргэжлийн хичээлийн чиглэлээр заавал судлах, сонгон суралцах чиглэлээр боловсруулагддаг. Уртын дуучин бэлтгэх ганцаарчилсан хичээлийн хөтөлбөр нь 2016 оноос шинэчлэгдсэн. 2021 онд дахин шинэчлэгдэн олон улсын дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн загварын дагуу боловсруулагдсан байна. Заавал судлах мэргэжлийн хичээлийн “Дуулах урлаг” хөтөлбөр нь D021503 индекстэйгээр 4 жилийн хугацаанд нийт 123 кредит цагийн хичээлийг үзэж дүүргэдэг байна.

*Хүснэгт 1. Хөтөлбөрийн баримталсан зарчим,
концетцийн харьцуулсан үр дүн*

Шалгуур	СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн хөтөлбөр	ӨМӨЗО-ны Хөх хот үндэстний дээд сургуулийн хөтөлбөр
Суурь бодлого	<p>Дээд боловсролын хөтөлбөр Монгол улсын их, дээд сургуулийн хууль тогтоомж, засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудад тулгуурлан боловсруулсан.</p> <p>Мэргэжлийн уртын дуулаач бэлтгэх сургалтын үйл ажиллагааны чиглэлтэй.</p> <p>Үр дүнд суурилсан мэргэжлийн боловсрол</p> <p>Мэргэжлийн дуулаач бэлтгэх хөтөлбөрийн загварчлалын дагуу агуулга, арга зүй, үнэлгээний өөрчлөлт шинэчлэлт хийсэн.</p>	<p>Дээд боловсролын хөтөлбөр БНХАУ-ын улс төрийн бодлого төлөвлөлтийг тусгасан.</p> <p>Дуулаач, дуу хөгжмийн багш бэлтгэх үйл ажиллагааны чиглэлтэй.</p> <p>Дуулаач бэлтгэх хөтөлбөр нь хэрэглээний хэлбэрт илүүтэй хамаардаг.</p> <p>Уламжлалт багш бэлтгэх боловсрол Сургалтын хөтөлбөр нь их сургуулийн баримталдаг хөтөлбөрийн төлөвлөлтийн хэсэгт ордог, тусгайлан загварчлалд оруулаагүй.</p>
Сургалтын төлөвлөгөө	<p>Багц хөтөлбөр</p> <p>Хөтөлбөрийн боловсролын үр дүн (PEO)</p> <p>Хөтөлбөрийн сургалтын үр дүн</p> <p>Сургалтын төлөвлөгөө</p> <p>Ерөнхий суурь (сонгох боломжтой)</p> <p>Дуулаач мэргэжлийн (сонгох боломжтой)</p> <p>Мэргэшлийн (сонгох боломжтой)</p>	<p>Багц хөтөлбөр багшийн стандарт</p> <p>Ерөнхий суурь (сонгох боломжгүй)</p> <p>Багш мэргэжлийн (сонгох боломж хязгаарлагдмал)</p> <p>Мэргэшлийн (сонгох боломжтой)</p>
Хичээлийн хөтөлбөр	<p>Хичээлийн стандарт</p> <p>Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (PLO)</p> <p>Үнэлгээ</p> <p>Хичээлийн товч тодорхойлолт</p> <p>Хичээлийн нэр, код багшийн мэдээлэл</p> <p>Ашиглах сурах бичиг</p> <p>Хичээлийн зорилго, зорилт агуулга</p> <p>Хичээлийн жишиг төлөвлөгөө</p>	<p>Зорилт, зорилго</p> <p>Агуулга /тодорхойлолт/</p> <p>Арга зүй</p> <p>Үнэлгээ жин</p> <p>Үнэлгээний зарчим</p> <p>Ном хэрэглэгдэхүүн</p>
Товч үнэлгээ	<p>Хичээл нэг бүрээр оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг хөтөлбөрийн үр дүнтэй уялдаатай тодорхойлж, сургалтын үйл ажиллагаа бүхэлдээ дуулаачийн мэргэжлийн үнэт зүйл эрхэм зорилго, хөтөлбөрийн сургалтын үр дүнг бүтээхэд чиглэн төлөвлөгдсөн.</p>	<p>Хөтөлбөрийн эцсийн үр дүнг тооцоолоход хязгаарлагдмал талууд үүссэн.</p>

Уртын дуу дуулаач бэлтгэх хичээлийн хөтөлбөр нь ерөнхий танилцуулга, зорилго, зорилтууд, сургалтын багц цаг, кредит цагийн хэмжээ, кредитийн хуваарилалт, сургагч багш, багшлах бүрэлдэхүүн, мэдээлэл, сургалтын хөтөлбөрийн тодорхойлолт, сургалтын гарын авлага, бусад нэмэлт хэрэглэгдэхүүн CD, DVD, цахим эх сурвалж ашиглах хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээл, суралцахуйн үр дүнгийн хамаарал, сургалтын төлөвлөгөө, сургалтын аргазүй буюу сургах, суралцах үйл ажиллагаа, суралцагчийн сурлагын чанарын баталгаажуулалт гэсэн 11 үндсэн хэсэгтэй байна. СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн “Дуулах урлаг” хөтөлбөр нь дуурийн дуу, уртын дуу, ардын дуу, орчин үеийн дуу дуулаачийн мэргэжил бүхий 11 хэсгээс бүрдсэн, тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөртэй байна. Уртын дууны хөтөлбөрт бэсрэг уртын дуунаас эхлэн, курс ахих тутамд суман болон айзам гэх мэт шат дараалалтай заагдах дуунуудыг оруулжээ. Жишээ нь, I-II курст “Хөөрхөн халиун”, “Сэвхэт бор”, “Төрөөс ээж”, “Оломгүй далай”, “Манарч байгаа шил”, “Зээргэнтийн шил”, “Цомбон туурайтай хүрэн” гэх мэт бэсрэг дуунуудаас эхлэн III-IV курст “Ар хөвчийн унага”, “Урьхан хонгор салхи”, “Эрхэм төр”, “Энх мэндийн баяр”, “Уяхан замба тив”, “Өвгөн шувуу хоёр”, “Дуртмал сайхан” зэрэг суман болон айзам дуунуудыг заадаг бол “Хөх хот” үндэстний дээд сургуульд уртын дуу дуулах тусгайлсан хөтөлбөр байхгүй учраас “Дуулах урлаг” хэмээх нэгдсэн хөтөлбөрийн дор уртын, ардын, нийтийн зэрэг дуунууд холилдож заагддаг. СУИС-ийн хөтөлбөрийн бүтэц, загвар нь олон улсын чиг хандлага, хөтөлбөр судлалын онол, зарчимд нийцэхүйц бүтэц, загвартай байна. Энэ нь мөн олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагатай нийцэж буй байдлаар тодорхойлогдох боломжтой (*Хүснэгт 2, 3, 4*).

Хүснэгт 2. СУИС, ӨМ-ын “Хөх хот” үндэстний дээд сургуулийн Дуулах урлаг-Дуу хөгжим хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний багц цагийн хуваарилалт / “Дуулах урлаг-Дуу хөгжим” хөтөлбөрийн жишээн дээр/

Хичээлийн төрөл	Заавал судлах хичээлийн багц цаг		Сонгон судлах		Нийт судлах хичээл		
			кредит хувь		кредит хувь		
	СУИС	Хөх хот дээд сургууль	СУИС	Хөх хот дээд сургууль	СУИС	Хөх хот дээд сургууль	
Ерөнхий суурь ба математик, суурь шинжлэх ухааны хичээлүүд /30%-аас ихгүй/	31	36	6	3	37	39	
Мэргэжлийн суурь хичээл /25%-аас ихгүй/	27	31	6	3	30	34	
Мэргэжлийн хичээл /45 хувиас багагүй/	Хичээлүүд, төслүүд	38	45	6	2	51	47
	Дадлага	4	4			4	9
	Төгсөлтийн шалгалт диплом	5	5			5	
Нийт дүн	105	121	18	8	123	129	

Хүснэгт 3. СУИС-ын ХУС-ийн “Дуулах урлаг” хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийн чиглэл

Хичээлийн нэр	Хичээлийн улирал	Хэлбэр	кр
Соноршуулга	Соноршуулга- I-VI	Бага бүлэг	6 кр
Дуулах ур чадвар	Дуулах ур чадвар I-VIII	Ганцаарчилсан	8 кр
Жүжиглэх ур чадвар	Жүжиглэх ур чадвар I-IV	Бага бүлгээр	4 кр
Найрал дуу	Найрал дуу I- VI,	Бүлгээр	6 кр
Төгөлдөр хуур	Төгөлдөр хуур I-II	Ганцаарчилсан	2 кр
Жүжгийн тавил	Жүжгийн тавил I-III	Бага бүлэг	3 кр
Удирдаачтай ажиллах	Удирдаачтай ажиллах I-II	Бүлэг	1 кр
Дуулаачийн цөөхүүл	Дуулаачийн цөөхүүл I-IV	Бага бүлэг	4 кр
Дуу заах арга зүй	Дуу заах арга зүй I-II	Бүлгээр	2 кр
Урлагийн түүх	Өрнө, Дорно, Монголын түүх	Бүлгээр	12 кр
Хөгжмийн онол	Хөгжмийн онол	Бүлгээр	8 кр
Нийт			56
Нийт Заавал суралцах 56 кр			

Хүснэгт 4. ӨМ-ын “Хөх хот” үндэстний дээд сургуулийн дуу хөгжмийн хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийн чиглэл

Хичээлийн нэр	Хичээлийн улирал	Хэлбэр	Кр
Дууны хичээл	Дууны хичээл I-VII	Ганцаарчилсан	7 кр
Баян хуур	Баян хуур I-VII	Ганцаарчилсан	7 кр
Төгөлдөр хуур	Төгөлдөр хуур I-VII	Ганцаарчилсан	7 кр
Дуу, хөгжим заах арга зүй	Дуу заах арга зүй I-III	Бүлгээр	3 кр
Урлагийн онол	Урлагийн онол I-II	Бүлгээр	2 кр
Концертмейстртэй нийлэх	Концертмейстртэй ажиллах I-II	Ганцаарчилсан	2 кр
Нот дуулах	Нот дуулах	Бүлгээр	2 кр
Заавал суралцах 30 кр			

Харьцуулалтын концепцийн ялгаа: СУИС-ийн болон ӨМӨЗО-ны “Хөх хот” үндэстний дээд сургуулийн дуулаач бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөрийг баримт бичгийн түвшинд харьцуулахад зарим онцлог ялгаатай байна.

СУИС-ийн сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн урлагийн хөтөлбөрийн хөгжлийн чиг хандлагатай илүүтэй нийцсэн байна. Хөтөлбөрийн бүтэц загвар нь төрийн бодлого, сургуулийн хөтөлбөр боловсруулах, баталгаажуулах тогтолцооны хувьд ӨМӨЗО-ны “Хөх хот” үндэстний дээд сургуулийн сургалтын хөтөлбөрөөс ялгаатай байна. Иймээс сургууль өөрийн онцлог, эрхэм зорилго, үнэт зүйл, хөгжлийн хандлага, алсын хараатайгаа холбож, бие даасан нарийн мэргэжлийн хөтөлбөр боловсруулах нь сургалтын хөтөлбөрийн хөгжилд илүү ач холбогдолтой болох юм.

ӨМӨЗО-ийн “Хөх хот” үндэстний дээд сургуулийн хөтөлбөрт суралцагчийн суралцахуйн үр дүнг тодорхойлох, үр дүнгийн хамаарлыг тооцох, чанарын баталгаажуулалтын хэсгийг тодорхой тусган сайжруулах шаардлага урган гарч байна. Тус сургуулийн хөтөлбөрийг багш бэлтгэх болон мэргэжлийн дуулаач бэлтгэх гэсэн чиглэлд бүлэглэн боловсруулах боломжтой.

Агуулга, аргазүйн харьцуулсан судалгаа хийж үзэхэд, ӨМ-ын “Хөх хот” үндэстний дээд сургуулийн 30 кредит бүхий хичээл байна. СУИС-ийн сургалтын төлөвлөгөөний хичээлээс даруй 26 кредитээр дутуу цаг судалж байна.

Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулахад ялгаатай болон ижил талууд гарч байгаа ч хамгийн гол нь элсэгчдийн хэл соёлын ялгаатай байдал нь үндэстний дархлаа болсон уртын дууг мэргэжлийн түвшинд дуулахад ачаалал болох эрсдэл нөхцөл болох талтай. *Хүснэгт 5*-д үр дүнд суурилсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд “Хөх хот” үндэстний дээд сургуулийн хөтөлбөр, бодлогод хийсэн SWOT шинжилгээг харуулав.

Хүснэгт 5. “Хөх хот” үндэстний дээд сургуулийн хөтөлбөр, бодлогод SWOT шинжилгээ

Давуу тал	Боломж
<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн уртын дуу дуулаач бэлтгэх баг бүрдэж байгаа. • СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн уртын дуу дуулаач бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр сургагдаж бэлтгэгдсэн багш нарын баг бүрдсэн. • Уртын дуу дуулаач бэлтгэх тэнхимтэй болсон. • “Хөх хот” үндэстний дээд сургуулийн дээд боловсролын хөтөлбөрийг боловсруулахад оролцостой болсон. 	<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн уртын дуучин бэлтгэх тэнхим • СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн уртын дуу дуулаач бэлтгэх сургалтын арга зүйгээр сургах чадвартай. • Мэргэжлийн дуулаач бэлтгэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж явуулах • Уртын дуучин бэлтгэх сургалтад үр дүнд суурилсан хөтөлбөрийг нэвтрүүлэх, сургалтын агуулгыг хөгжүүлэх, арга зүйн хичээлүүд оруулж, сургалтын үйлчилгээгээ тэлэх
Сул тал аюул	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> • Багш бэлтгэх боловсролын хичээлийн агуулга алга болох • Бэлтгэгдэн гарах багш боловсон хүчний тоо багасах • Багш нарын хичээлийн цагийн ачаалал багасах • Чанаргүй дуулаачийн тоо нэмэгдэх • Эрдмийн зэрэгтэй багш нарын тоо цөөн • Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тоо цөөн 	<ul style="list-style-type: none"> • Дуу хөгжмийн багш мэргэжлээр элсэгчдийн тоо цөөрөх • Төгсөгчдөд ажлын байрны хомсдол үүсэх • Сургалтын орчин үеийн техникийн чиглэлээр хоцрогдмол • Гадаад зах зээлд гарах боломж хязгаарлагдмал • Монгол хэл дээрх судалгаа шинжилгээний ажлыг хөгжүүлэхэд хэл, соёлын ялгаатай.

Дүгнэлт

1. ӨМӨЗО-ны “Хөх хот” үндэстний дээд сургуулийн дуулаач бэлтгэх хөтөлбөр нь дуурийн дуучин, уртын болон ардын дуучин, орчин үеийн дуучин бэлтгэхэд чиглэсэн тусгайлсан хөтөлбөргүй нэгдсэн хөтөлбөртэй байна.
2. СУИС-ийн хөтөлбөрийн бүтэц загвар нь олон улсын чиг хандлага, хөтөлбөр судлалын онол, зарчимд нийцэхүйц бүтэц, загвартай ба суралцахуйн үр дүнд суурилсан хөтөлбөртэй байна.
3. Мэргэжлийн уртын дуу дуулаач бэлтгэх сургалтын онол арга зүйг судлах замаар ӨМӨЗО-ны “Хөх хот” үндэстний дээд сургуулийн уртын дуу дуулаачаар суралцаж буй суралцагчдын дуулах ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан, хөтөлбөрийн шинэчлэл хийж, үр дүнг туршин судлах шаардлагатай хэмээн дүгнэлээ.

Ашигласан материалын жагсаалт

1. Stufflebeam, D. 1983. *The CIPP Model for Program Evaluation. Viewpoints on Educational and Human Services Evaluation*, Kluwer, Norwell
2. Боловсролын хэрэг эрхлэх яам. 2012. *Өндөр зэргийн сурган хүмүүжүүлэх чанар чансааг дээшлүүлэх тухай санал. Өндөр зэргийн сурган хүмүүжлийн чанар чансааг бүх талаар дээшлүүлэх хурлын эмхэтгэл. Бээжин хот, БНХАУ: Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.*
3. Жилээ, Ж., Тамир, Х., Дэлгэржаргал, М. 2020. *Сургалтын хөтөлбөрийн харьцуулсан судалгаа*. Улаанбаатар, Монгол Улс: Соёмбо принтинг ХХК.
4. Манда. 2018. *Бакалаврын боловсролын чанарыг дээшлүүлж, их дээд сургуулийн чанартай хөгжлийг биелүүлэх нь. Боловсролын чанар үр дүн*. Улаанбаатар, Монгол Улс: Монгол улсын боловсролын их сургууль.
5. Мандалт. 2018. *Уртын дууны сургалтын заах арга зүйн судалгаа. Боловсролын чанар, үр дүн* Улаанбаатар, Монгол Улс: Монгол улсын боловсролын их сургууль.
6. Улаан, 2018. *Их дээд сургуулийн боловсролын чанарыг дээшлүүлэх талаарх шинжилгээ. Боловсролын чанар үр дүн*. Улаанбаатар, Монгол Улс: Монгол улсын боловсролын их сургууль.
7. СУИС. 2015. *Дүрэм журмын эмхэтгэл*. Улаанбаатар, Монгол Улс.